



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/692

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 14.500.000 (арван дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийн санхүүжилтээр нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор иргэдэд мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г. Болдбаатар)-т шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, гүйцэтгэгчийн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л. Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ
ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ
О.АМГАЛАНБААТАР

